



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/195

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11 дэх заалт, Монгол Улсын Их хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, “Төлөвлөгөө батлах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/607 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга  
Нарийн бичгийн дарга: (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: Засаг даргын Тамгын газрын төсвийн ерөний нягтлан  
бодогч

Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн  
Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Мал эмнэлгийн улсын байцаагч  
Хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан  
Нийгмийн бодлогын мэргэжилтэн  
Эрүүл мэндийн төвийн дарга  
Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд  
Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын  
эрхлэгч нар  
Багийн Засаг дарга нар

2. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар ханган, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



My Doc Zakhiramj /ZD/2023

629301403